Монгол улс дахь “ЭВТАНАЗИ”-ийн эрх зүйн зохицуулалт

С.Чулуунсүх[1], Х.Дамдинжав[2], Ц.Түвшинжаргал[3], М.Цэрэнбат[3]

[1]ШШҮХүрээлэн ШЭШГазар,
[2]АШУҮИС НЭМС,
[3]АШУҮИС-БиоАС
Цахим хаяг: chuluunsukh.togs1981@gmail.com, Утас:99234939

Түлхүүр үг:

Амар үхэл
Зовиургүй үхүүлэх
Дэмжлэгтэй амиа хорлолт
Идэвхтэй болон идэвхгүй эвтанази
Хүний эрх
Үйлчлүүлэгчийн эрх
Амьдралын төгсгөл

Товч утга: Эвтанази нь хүний амьд явах эрхтэй шууд хамааралтай эмзэг сэдвийн нэг бөгөөд цаашид хүний амьдрах уу үхэх үү гэдгийг шийдэх өөрөөр хэлбэл нийгмийн сэтгэл зүйд шууд нөлөөлөх сэдэв юм. Эвтанази нь нийгмийн олон талт харилцааны бүрдэл болохын хувьд энэ нь өөртөө ёс зүй, анагаах ухаан, хууль зүйн шинжлэх ухаан болон шашин, зан заншлын хэм хэмжээг өөртөө агуулсан цогц ойлголт юм. Манай улсын болон гадаад орнуудын хууль зүй судлалын хөгжлийн төлөв, чиг хандлагаас урган гарсан эвтаназийн тухай асуудал нь байнга сөхөгдсөөр ирсэн авч өнөө хэр нэгдсэн шийдэлд хүрээгүй байна. Монгол Улсын эрүүл мэндийн тухай хууль болон эмнэлгийн эрх зүйн бусад актуудад эвтаназийг хориглосон заалт байхгүй, эмчилгээнээс татгалзах эрхийг нээлттэй байдлаар зохицуулсан атлаа эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзвэл эвтаназид эрүүгийн хуулиар хориглолт бий болгожээ. Тухайлбал эмч үйлчлүүлэгч буюу түүний ойр дотны хүмүүсийн зөвшөөрлийн дагуу эвтанази хийвэл Монгол улсын 2015 оны эрүүгийн хуулийн 10.1-д зааснаар гэмт хэрэг өдүүлсэнд тооцогдож 8-15 жилийн хорих ял авахад хүрнэ. Тэгээд ч Улсын Дээд Шүүхийн 2010 оны нэгдсэн тайлбарт хохирогчийн зөвшөөрөлтэйгээр түүний амь насыг егүүтгэснийг энэ зүйл хэсгээр зүйлчилж байхаар тусгажээ.

Үндэслэл: Эрх зүйн орчны талаарх эмч эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн асран хамгаалагчдын мэдлэг, хандлагыг тодорхойлж Анагаах ухаан, хууль зүйн талаас нэгтгэсэн судалгаа хийгдээгүй, мөн Монгол Улсад Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хөгжөөд 20 жил болж байгаа бөгөөд өвчтний өвдөлт, өвчин шаналалыг эм тарианы тусламжтай намдаадаг болсон нь нэг талаас үхэх эрхийг хүсэхгүй байхыг нэмэгдүүлсэн байж болзошгүй, нөгөө талаас Ардчилсан нийгэм хөгжсөнөөр хүний эрхийн асуудал өндрөөр тавигдах болсон энэ үед хүний үхэх эрхийн асуудал хөгжсөн байхыг үгүйсгэхгүй учир судалгаа хийх үндэслэл болсон.

Зорилго: Эвтаназийн эмнэлгийн эрх зүйн зохицуулалтын онцлогийг судлах

Зорилт:

1. Монгол Улсад эвтаназийн эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголтыг анагаах ухаан, ёс зүйн болон хууль эрх зүйн талаас нь нэгтгэн судалж, үйлчлүүлэгчид, тэдгээрийн асран хамгаалагч, эмнэлгийн мэргэжилтнүүд, АШУҮИСургуулийн оюутнуудын эвтаназийн тухай мэдлэгийг үнэлэх
2. Эвтаназийн Үндэсний эрх зүйн зохицуулалтыг судлах
3. Эвтаназийн Олон Улсын эрх зүйн зохицуулалтыг судлах

Материал, арга зүй: Судалгааг Аналитик судалгааны агшингийн загвар ашиглан явуулж зорилтот түүврийн бүлэг болох эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд, үйлчлүүлэгч, тэдгээрийн асран хамгаалагчид,

оюутнуудаас асуумж судалгаа авсан. Судалгааны үр дүнг STATA-15 программаар үнэлэв.

Түүвэрлэлтийн хэмжээг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн томьёогоор бодож үзвэл:

$$n = \frac{N \times p \times (100-p) \times Z_{\alpha/2}{}^2}{(N-1) \times e^2 + p \times (100-p) \times Z_{\alpha/2}{}^2} = \frac{1500 \times 50 \times (100-50) \times 1.96^2}{(1500-1) \times 4^2 + 50 \times (100-50) \times 1.96^2} = 429$$

N – Эх олонлогийн хэмжээ (N = 1500)

p – Судалж буй үзэгдлийн тархалт (p = 50%)


$Z_{\alpha/2}$– Статистик ач холбогдлын түвшин ($Z_{\alpha/2}$ = 5% = 1.96)

e – Алдааны хязгаар (e = 4%)

Судалгааны ажлын ач холбогдол: Эвтаназийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор Монгол улсад хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад ач холбогдолтой. Эвтаназийн эрх зүйн зохицуулалтын талаар судалгааг зөвхөн хууль эрх зүйн үндэслэлийг тодорхойлох оролдлогоор хязгаарлалгүй эвтаназийн харьцуулсан судлал, эрүүгийн эрх зүй, эмнэлгийн эрх зүй болон анагаах ухаан, ёс зүйн уялдаа холбоонд нь авч үзсэнээрээ тулгамдаж буй зорилт шаардлагыг хангаж хэрэгжүүлэх учиртай. Түүнчлэн эдүгээ дэлхийн улсуудын эмнэлгийн эрх зүй, эрүүгийн эрх зүй нь хүмүүнлэг чиг хандлага эрч хүчээ авч эвтаназийг хуулиар зөвшөөрөх үйл явц идэвхжиж буй өнөө үед энэхүү сэдвийг тусгайлан судлах нь өнөөгийн тулгамдсан асуудал ярианүй мөн.


Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад эвтаназитай холбогдох заалтуудыг тодруулж хууль хэрэглээг нэг мөр болгох, эдгэршгүй өвчтэй, өвчний төгсгөлийн шатанд буй үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, эмч нар, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажиллах эрх зүйн орчинг тодорхой болгоход чиглэгдсэн суурь судалгаа болсноор практикийн ач холбогдолтой.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан эмч нарын эвтаназийн талаарх ерөнхий ойлголтыг лавлаж асуухад эмч нарын 20 гаруй хувь мэднэ гэж хариулсан бол, дийлэнхи хэсэг нь мэдэхгүй гэж хариулсан байна (Зураг 1).




Зураг 1. Эвтаназийн талаарх эмч нарын ойлголт

Эвтаназийн хүсэлт үйлчлүүлэгчээс эмч нарт тавьж байсан эсэхийг эмнэлгээр нь ялган судлахад дийлэнхи буюу 80 хувь Хавдар судлалын үндэсний төвийн, 12 хувь улсын хоёрдугаар төв эмнэлгийн, 6 хувь Улсын клиникийн төв эмнэлгийн үйлчлүүлэгч байсан бол 2 хувь буюу цөөн үйлчлүүлэгч Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хандсан байна. (Зураг 2).




Зураг 2. Үйлчлүүлэгчийн зүгээс эмчид эвтаназийн хүсэлт тавьж байсан байдал

Харин эмч нарт өвчтөний ар гэр, асран хамгаалагч болон хууль ёсны төөлөөлөгчийн зүгээс эвтаназийн хүсэлт тавьж байсан эсэхийг эмнэлгээр нь тодруулж судлахад 67% ХСҮТ, 17% ЭХЭМҮТ, 11% УХТЭ, 5% УНТЭ-ээс хандсан байжээ. (Зураг 3).




Зураг 3. Ар гэр, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчийн зүгээс

Эвтанази ёс зүйд нийцэх эсэхийг эмч нарын эрүүл мэндийн байгууллагад ажилласан жилтэй харьцуулж үзэхэд 11-ээс дээш ажилласан эмч нарын 41%, 6-10 жил ажилласан эмч нарын 34%, 1-5 жил ажилласан эмч нарын 25% нийцнэ гэж үзжээ. Эмч нарын ажилласан жил нэмэгдэх тусам эвтанази ёс зүйд нийцнэ гэж үзэх хандлагатай байлаа. (Зураг 4).




Зураг 4. Ёс зүйд нийцэх эсэхийг эмч нарын ажилласан жилээр ангилж үзэхэд

Түүнчлэн эмч нарын эвтаназийг хуульчлах шаардлагатай эсэх үзэл бодлыг тодруулж асуухад ихэнхи хувь нь буюу 11-с дээш жил ажилласан хүмүүс хуульчлах хэрэгтэй гэж боддогоо хэлжээ. (Зураг 5)




Зураг 5. Эвтаназийг хуульчлах талаархи эмч нарын үзэл бодол

Эмч нар эвтаназийн талаар ямар нэгэн байдлаар сонсож байсан эсэхийг эрүүл мэндийн байгууллагад ажилласан жилээр задлан үзэхэд сонсож байсан гэж дийлэнхи хувийг хариулсан хүмүүс нь 1-5 жил ажилласан эмч нар байлаа. Харин ажилласан жил нэмэгдэх тусам эвтаназийн талаар эмч нар бага сонссон байна. Энэ нь эвтаназийн талаарх ойлголт сүүлийн үед эрүүл мэндийн салбарт хөгжиж буйг харуулж байна (Зураг 6).



Зураг 6. Эвтаназийн талаар эмч нарын сонсож байсан байдлыг ажилласан жилээр авч үзэхэд

Мөн судалгаанд хамрагдсан эмч нарын эвтаназийн төрлүүдийн талаар мэддэг эсэхийг асуухад нийт 50 эмчийн 52% нь эвтаназийн төрлүүдийг мэддэг, харин 48% нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ (Зураг 7).




Зураг 7. Эвтаназийн төрлүүдийн талаарх эмч нарын ойлголт


Эвтанази ёс зүйд нийцэх эсэхийг эмч нарын эрүүл мэндийн байгууллагад ажилласан жилтэй харьцуулж үзэхэд 11 дээш ажилласан эмч нарын 41%, 6-10 ажилласан эмч нарын 34%, 1-5 жил ажилласан эмч нарын 25% нийцнэ гэж үзжээ. Эмч нарын ажилласан жил нэмэгдэх тусам эвтанази ёс зүйд нийцнэ гэж үзэх хандлагатай байлаа. (Зураг 8)



Зураг 8. Эвтаназийг ёс зүйд нийцэх эсэх талаар эмч нарын бодол




Зураг 9. Эвтанази ёс зүйд нийцэх эсэх ажилласан жилээр



Зураг 10. Эвтанази ёс зүйд нийцэх эсэх талаар асран хамгаалагчдын бодол

Судалгаанд оролцсон нийт 47 ар гэрийнхний эвтанази ёс зүйд нийцнэ гэж хариулсан хүмүүсийн 21.2% нь урьд өмнө нь энэ талаар сонсож байсан бол 53.2% сонсож байгаагүй гэжээ. Харин эвтанази ёс зүйд нийцэхгүй гэж хариулсан ар гэрийнхэний 4.2% энэ талаар урьд өмнө нь сонсож байсан бол 21.2% огт сонсож байгаагүй гэсэн байна. Эвтаназийн талаар ёс зүйн зохицуулалт хийх шаардлагатай эсэхийг үйлчлүүлэгчийн ар гэр, асран хамгаалагч нараас лавлан асуухад 87% тийм гэж хариулсан бол 13% шаардлагагүй гэж үзжээ.




Зураг 11. Эрх зүйн зохицуулалт хийх нь асрамжилсан хугацаанаас хамаарах эсэх

Түүнчлэн өвтөнийг асран халамжилж буй ар гэрийн хүмүүсээс эвтаназийг эрх зүйн зохицуулалт хийхийг дэмжиж байгаа эсэхийг асран хамгаалж буй хугацаанаас хамаарч буй эсэхийг тодрууллаа. 1-6 сар асрамжилсан 18 хүн /38.2%/, 6-12 сар асрамжилсан 6 хүн /12.7%/, 1-5 жил асрамжилсан 16 хүн /34.0%/, 5-10 жил асрамжилсан 7 хүн /14.8%/ дэмжихээ илэрхийлсэн байна. Үйлчлүүлэгчийн ар гэр эрх зүйн зохицуулалтыг

дэмжиж байгаа эсэх нь асрамжилсан хугацаанаас төдийлөн хамаарахгүй байна (p=0.884). (Зураг 11).

Мөн судалгаанд оролцогчдоос хэрэв эвтаназийн талаар эрх зүйн зохицуулалт хийгдвэл асран хамгаалагчид нь хэрхэн хүлээж авахыг тодруулахад 89% нь хуульчилсан тохиолдолд дэмжинэ, харин 11% дэмжихгүй гэсэн саналтай байгаагаа хэлжээ (Зураг 12)



Зураг 12. Хуульчилсан тохиолдолд асран хамгаалагч нь дэмжих эсэх

Дүгнэлт:

1. Эвтаназийн талаарх эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн анагаах ухаан, хууль эрх зүйн мэдлэгийг үнэлсэн дүн: Судалгаанд оролцсон нийт эмч нарын 96% нь эвтаназийн талаар сонсож байсан ба бусад нь эвтаназийн талаар сонсож байгаагүй бөгөөд эвтаназийн талаарх ойлголт туйлын хангалтгүй байна.
2. Үйлчлүүлэгчдийн ар гэрийнхний эвтаназийн талаарх ойлголт, хууль эрх зүйн мэдлэгийг судалсан дүн: Судалгаанд оролцогч ар гэрийнхний 74,5% нь эвтаназийн талаар урьд өмнө нь сонсож байгаагүй байна. Хүнд болон өвчний төгсгөлийн шатанд орсон өвчтнүүдийн ар гэрийнхэний дийлэнхи буюу 74% нь эвтаназийг ёс зүйд нийцнэ гэж үзжээ.
3. Монгол Улсад эвтаназийн талаар хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судалж, олон улсын эрх зүйн заалтуудтай харьцуулан үнэлсэн дүн: Харьцуулсан судалгаагаар эвтаназийн эрх зүйн зохицуулалтыг Нидерланд, Бельги, Швейцарь, Франц, Герман, Люксембург, АНУ-ын Калифорни, Орегон, Вашингтон муж улсууд, Австралийн хойд бүс, Израиль, Япон болон ОХУ, тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудыг жишиг болгон судлав. Одоогоор Дэлхий дахинд Идэвхтэй эвтаназийг дэмжсэн дараах улсууд байна. Үүнд: Голланд /2002/, Франц /2004/, Швейцарь /2005/, Люксембург /2009/, Канад /2016/, Бельги /2014/, Итали /2018/, АНУлсын Орегон /1998/, Монтана /2008/, Вашингтон /2009/, Вермонт /2013/, Калифорни /2015/, Колорадо /2016/, Герман /2015/, Колумб /2015/, Австрали /2019/ зэрэг байгаа ба жил ирэх тусам эвтаназийг дэмжиж буй орнуудын тоо өссөөр байна. Мөн Дэлхий дахинд идэвхгүй эвтаназийг хуульчилсан Энэтхэг /2011/, Израйль /2005/, Өмнөд Солонгос /2016/, Мексик /2008/ гэх мэт 60-аад орон байгаа бөгөөд Монгол улс 2013 оны 11 сарын 25-ны өдрийн ЭМСайдын 446 тоот тушаалаар үйлчлүүлэгчийн эмчилгээ, үйлчилгээнээс татгалзах эрхийг баталгаажуулж өгсөн нь идэвхгүй эвтаназийг хуульчилж өгсөн явдал юм.

Ном зүй:

1. *"Rights of the terminally ill act" http://www.nt.gov.au/lant/parliament/committees/rotti/illregs.pdf*
2. *С.Нарангэрэл, "Эрх зүйн эх толь бичиг", 2010 он, хх 216*
3. *Steven H. Gifis, 'Law Dictionary' (2003), fifth edition, 180*
4. *Тищенко П. Д. Эвтаназия: российская ситуация в свете американского и голландского опыта // Медицинское право и этика. – 2000. – № 2. – С.33.*
5. *Emily Jackson, 'Medical law, End of life decision' (2006), 911*
6. *Медицинская газета. 1997. № 96.*
7. *Э.Ганбат, М.Цэрэнбат, "Шүүх эмнэлэг", 2005, 119*
8. *Крылова Н.Е. Уголовное право и биоэтика: проблемы, дискуссии, поиск решений. - Инфра-М, Москва, 2006.*
9. *"Death with Dignity Act" http://www.deathwithdignity.org/*
10. *Төрийн мэдээлэл, Эрүүл Мэндийн Тухай Хууль, 2011 оны 05 дугаар сарын 05*
11. *Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралт*
12. *Тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудас, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн 446 тоот тушаалын долдугаар хавсралт*
13. *Монгол Улсын Дээд шүүхийн "Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг тайлбарлах тухай" 2009 оны 14 дүгээр тогтоол*
14. *Монгол Улсын Дээд Шүүхийн мэдээлэл, 1996 оны №2, 12 хх*
15. *Донорын тухай хууль, Төрийн мэдээлэл, 2000.02.18, №6*
16. *"Монгол Улсын Эрүүгийн Хуулийн тайлбар", Монгол Улсын Дээд шүүх, 2010 он, 220 хх*
17. *Niderlandse Jurisprudentie 1973 No 183 District court of Leeuwarden 21 Feb 1973*
18. *Wertheim, Nederlandse Jurisprudentie 1982 No 63 Rotterdam Criminal Court*
19. *T Sheldon, 'Being 'tired of life' is not grounds for euthanasia' (2003) 326 BMJ 71*
20. *Termination of life on Request and Assisted suicide, http://www.nvve.nl/assets/nvve/english/euthlawenglish.pdf*
21. *E Jackson, 'Medical law, End of life decision' (2006), 963*
22. *New England Journal of Medicine, The Groningen Protocol — Euthanasia in Severely Ill Newborns, Volume 352:959-962*
23. *Российский научный онкологический центр" ОХУ-ын анагаах ухааны мэдээллийн портал / www. oncocenter.ru. - 12.05.2009.*
24. *Loi relative a l'euthanasie (The Act concerning Euthanasia), 28 May 2002, in force 23 Sept 2002*
25. *Assisted Dying for the Terminally ill Committee, Assisted Dying for the Terminally ill Bill-First report (2005) 74*
26. *Арьес Ф. Человек перед лицом смерти./ «Прогресс-Академия». - 1992. - 527с.*
27. *Washington at al v Glucksberg 117 SCt 2258 (1997) SCt 2293 (1997)*
28. *http://egov.oregon.gov/DHS/ph/pas/docs/statute.pdf*
29. *Oregon Department of Human Services, Seventh Annual Report on Oregon's Death with Dignity Act (2004) http://egov.oregon.gov/DHS/ph/pas/docs/year7.pdf*
30. *Oregon v John Ashcroft Ninth circuit Court of Appeals (2004) No 02-35587*

“Legal regulation of Euthanasia in Mongolia”

Chuluunsukh S[1], Damdinjaw Kh[2], Tuvshinjargal Ts[3], Tserenbat M[3]

[1]Department of Forensic medicine, Mongolian National Institute of Forensic Science
[2]School of Public Health, Mongolian National University of Medical Science
[3]School of Bio-Medicine, Mongolian National University of Medical Science
Email: tserenbat@mnums.edu.mn, chuluunsukh.togs1981@gmail.com, Tel: 99234939

The euthanasia is still unsolved all around the world in the medicine-ethics, legal science, religion and it’s problematic, especially among lawers, doctors, politicians, monarchs. Euthanasia is an ancient Greek word, and it means that the “eu” is good, “thanatos” death. Although the Health Law of Mongolia and other legal acts do not prohibit euthanasia and patient has a right to refuse treatment. But on the opposite side the criminal law prohibition is still valid by the explanation of Supreme court of Mongolia. For example, if a doctor performs euthanasia with the consent of a client or his / her relatives, he / she will be considered a criminal and sentenced to 8-15 years in prison according to Article 10.1 of the 2015 Criminal Code of Mongolia.

Moreover, the 2010 Supreme Court's General Interpretation states that the killing of a victim with the victim's consent should be categorized as such. Legal practitioners of environmental health officers and the lack of action identified for families of consumer awareness, attitude is the basis of our research. Since no such study has been conducted before, we intend to conduct this study because there has not been done any comprehensive medical and legal survey to determine the knowledge and attitudes of physicians and caregivers of patients about the legal environment. Furthermore the palliative care has been developed in Mongolia for 20 years which can relieve pains and other issues made patient and their family don not seek decline treatment. On the other hand, the development of a democratic society raises the issue of human rights at a time when human rights issues are on the rise.

Evaluation of medical and legal knowledge of euthanasia in physicians : Ninety-six percent of the physicians surveyed had heard of euthanasia, the rest had never heard of euthanasia, and their understanding of euthanasia was extremely poor. Results of a survey of clients 'families' understanding of euthanasia and legal knowledge: 74.5% of the surveyed households had never heard of euthanasia. The vast majority or 74% of the families of patients with severe or end-stage disease considered euthanasia to be ethical.

Keywords: easy death, painless death, supportive suicide, active and passive euthanasia, human rights, client rights, end of life